

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 02 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 13 цаг 50 минутад эхэлж, мөн өдрийн 18 цаг 40 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 4 цаг 50 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Улсын хошой аварга малчин”, “Улсын аварга малчин” шалгаруулах тухай	<p>1. “Улсын хошой аварга малчин өрх” шалгаруулах журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Ховд аймгийн Булган сумын Байтаг багийн Улсын аварга малчин Дугаржавын Давааг “Улсын хошой аварга малчин өрх”-өөр</p> <p>2. Улсын аварга малчин өрх шалгаруулах журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Ховд аймгийн Дарви сумын Дэлгэр багийн малчин Галсандоржийн Ганбаатар, Дуут сумын Хөхбэлчир багийн малчин Самданы Даваахүү, Мөнххайрхан сумын Алаг багийн малчин Шаравын Төмөрхуяг, Зэрэг сумын Гүвээ багийн малчин Баатарын Хүрэлдовчин, Мянгад сумын Баянбулаг багийн малчин Лхамсүрэнгийн Пүрэвсан, Чандмань сумын Баянхайрхан багийн малчин Доржийн Анхбаяр, Манхан сумын Баянгол багийн малчин Бовоогийн Болдоо, Булган сумын Алагтолгой багийн малчин Аэрфаланы Баатархуяг нарыг “Улсын аварга малчин өрх”-өөр тус тус шалгаруулахаар дэмжиж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хугацаанд нь хүргүүлэхийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Бямбажавд үүрэг болгов.</p>
2	“Улсын аварга тариаланч” шалгаруулах тухай	“Улсын аварга тариаланч” шалгаруулах журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан багийн тариаланч Долдойн Аманжол, Бадарчийн Цогтсайхан, Мянгад сумын Баянхошуу багийн тариаланч Баттогтохын Отгонтөгс, Жаргалант сумын Алагтолгой багийн тариаланч

		Мижиддоржийн Цэцэгсүрэн нарыг “Улсын аварга тариаланч”-аар шалгаруулахаар тус тус дэмжиж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хугацаанд нь хүргүүлэхийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Бямбажавд үүрэг болгов.
3	Аймгийн аварга малчин, аймгийн хошой аварга малчин шалгаруулах журам хэлэлцүүлэх тухай	Аймгийн аварга малчин өрх, аймгийн хошой аварга малчин өрх шалгаруулах журам хэлэлцүүлэхэд шинэ журамыг хойшлуулж, энэ жил аймгийн аварга малчин өрх, аймгийн хошой аварга малчин өрх шалгаруулахдаа хуучин журмаар шалгаруулаж 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Бямбажав нарт үүрэг болгов.
4	Хүнс, хөдөө аж ахуйн газрын ажилтан албан хаагчдын гаргасан өргөдөл гомдлын дагуу ажлын хэсэг томилогдон ажилласан хяналт шалгалтын дүн танилцуулах тухай	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, шинэ мөрийн хөтөлбөрийг биелүүлэхэд баг болж ажиллах багийг бүрдүүлэхэд олон хүний асуудал яригдана. Намын тэргүүлэгчдийн хурлаар газар, хэлтэс, агентлагын дарга нар болон намын боловсон хүчний асуудлыг хэлэлцэхэд дахин хэлэлцүүлэхээр болов.
5	2021 оны Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах тухай	2021 оны аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг дахин хянаж, хэлэлцэх явцад гарсан саналыг тусган батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР